

ГАРЧИГ

1. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА	2
1.1 Төслийн ерөнхий мэдээлэл	2
1.2 Төслийн хүчин чадал	3
1.3 Төслийн дэд бүтэц	5
БҮЛЭГ 2. ТӨСЛИЙН ТАЛБАЙ ТҮҮНИЙ ОРЧМЫН БАЙГАЛЬ ОРЧНЫ ТӨЛӨВ БАЙДЛЫН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ	8
2.1 Төсөл хэрэгжих талбайн байршил, физик газарзүйн нөхцөл	8
2.2 Төсөл хэрэгжих орон нутгийн уур амьсгал	8
2.3 Төсөл хэрэгжих талбайн хөрсөн бүрхэвч	9
2.4 Төсөл хэрэгжих талбайн ургамлан нөмрөг, амьтны аймаг	9
2.5 Төсөл хэрэгжих талбайн гадаргын болон гүний ус	10
2.6 Төсөл хэрэгжих орон нутгийн нийгэм эдийн засгийн байдал	11
3. ТӨСЛИЙН ГОЛ БОЛОН БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛӨЛ	13
3.1 Төслийн үйл ажиллагаанаас агаарын чанарт үзүүлж болзошгүй гол сөрөг нөлөөлөл	13
3.2 Төслийн үйл ажиллагаанаас хөрсөн бүрхэвч, ургамлан нөмрөгт үзүүлж болзошгүй гол сөрөг нөлөөлөл	13
3.3 Төслийн үйл ажиллагаанаас гадаргын болон газрын доорх усанд үзүүлж болзошгүй гол сөрөг нөлөөлөл	13
3.4 Төслийн үйл ажиллагаанаас Хүний эрүүл мэндэд үзүүлж болзошгүй гол сөрөг нөлөөлөл	14
4. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГОЛ ЗОРИЛТ, ХАМРАХ ХҮРЭЭ	15
5. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө	17
6. Нөхөн сэргээлтийн ажлын төлөвлөгөө	20
7. Тэрбум мод тарих арга хэмжээний төлөвлөгөө	21
8. Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох төлөвлөгөө	21
9. Түүх, соёлыг өвийг хамгаалах төлөвлөгөө	21
10 Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө	22
11. Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөө	23
12. Хог, хаягдлын менежментийн төлөвлөгөө	24
13 Орчны хяналт-шинжилгээний хөтөлбөр	25
14 Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө	28
15. БОМТ-г хэрэгжилтийн нөлөөлөлд өртөгч оршин суугчид, оролцогч талуудад тайлагнах төлөвлөгөө	29

1. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

1.1 Төслийн ерөнхий мэдээлэл

Төслийн нэр: “Шандын ам” алтны шороон ордыг ил уурхайн аргаар ашиглах төсөл

Төсөл хэрэгжүүлэгч: “ЛМО” ХХК

Улсын бүртгэлийн дугаар: 9019082125

Регистрийн дугаар: 5619483

Албан ёсны хаяг: Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг, 11-р хороо, 118-129 тоот

Ашигт малтмалын тусгай зөвшөөрлийн дугаар:


MV-020482

Төслийн байршил: “ЛМО майнинг” ХХК нь Төв аймгийн Лүн сумын нутаг дэвсгэрт байрлах MV-020482 тусгай зөвшөөрлийн дугаартай 154.28 га газрыг, газар эзэмших эрхийн гэрчилгээг ашигт малтмалын ашиглалт зориулалтаар эзэмшдэг байна.

Шандын амны алтны шороон орд нь засаг захиргааны хувьд Төв аймгийн Лүн сумын нутагт оршино. Улаанбаатар хотоос баруун зүгт 160 км, Лүн сумаас баруун урагш 25 км, Улаанбаатар-Төв чиглэлийн хатуу хучилттай замын хойд талд 2 км зайд оршино. Талбай нь номенклатурын хувьд L-48-7 планшетад байрладаг. MV-020482 дугаартай тусгай зөвшөөрлийн талбайн булангийн цэгүүдийн солбилцолыг хүснэгтэд үзүүлэв.

Хүснэгт 1. Тусгай зөвшөөрөлтэй талбайн эргэлтийн цэгийн солбицол

№	Уртраг	Өргөрөг			
1	105° 0' 46.09"	47°45'1.78"	7	105° 1' 41.08"	47°44' 1.78"
2	105° 0' 46.09"	47°44' 46.78"	8	105° 1' 41.10"	47°44'19.78"
3	105° 1' 36.08"	47°44' 46.78"	9	105° 0' 51.09"	47°44'19.78"
4	105° 1' 36.08"	47° 44' 21.79"	10	105° 0' 51.09"	47°44'36.78"
5	105° 2' 6.09"	47°44' 21.79"	11	105° 0' 21.09"	47°44'36.78"
6	105° 2' 6.08"	47°44' 1.78"	12	105° 0' 21.09"	47°45'1.78"



Зураг 1. Төсөл хэрэгжих талбайн байршил

1.2 Төслийн хүчин чадал

Уурхайн жилийн хүчин чадал нь жилд 180 мян.м3 элс байна. Ордын хэмжээнд хаягдал бохирдол тооцсоноор, угаах элсний нийт хэмжээ 316.7 мян.м3 бөгөөд уг хүчин чадлаар уурхайг ашиглахад, ашиглалтын хугацаа нийт 2 жил байна.

Олборлолтын явцад хуулсан хөрсийг түр гадаад овоолго болон дотоод овоолгод, олборлосон элсийг элс угаах талбайд тээвэрлэн хүргэнэ.




График 1. Уурхайн календарчилсан төлөвлөгөө

Уурхайн ажиллах горим

Уурхай нь улирлын чанартай ажиллах бөгөөд жил бүрийн 4-р сарын эхнээс 10-р сарыг дуустал ажиллана. Уулын ажлыг нийт 6 сарын хугацаанд явуулах ба уурхай нь 4-р сарын 15-аас эхлэн уурхайн бэлтгэл ажлууд болон хөрс хуулалтын ажлыг эхлүүлж, 5-р сарын 15-наас 10-р сарын 15 хүртэл элсээ олборлон угаах ажиллагааг явуулна


Уурхай нь улирлын чанартай үйл ажиллагаа явуулах учир олборлолт явуулах үед тасралтгүй ажиллана. Улсын чанартай баяр ёслолын өдрүүдэд амарна. Харин техник, тоног төхөөрөмжүүдэд үзлэг үйлчилгээ, урсгал засвар хийхээр сард 2 хоног байхаар төлөвлөсөн байна.

Хүснэгт 2. Уурхайн ажиллах горим

Д / д	Үзүүлэлт	Хэмжих нэгж	Хэмжээ	Тайлбар
1	Жилийн календарь хугацаа	хоног	366	
2	Жилд ажлын хоног	хоног	214	
3	Жилд ногдох ажлын бус хоног	хоног	6	Баяр ёслол
		хоног	7	Цаг агаарын саатал болон төлөвлөгөөт бус сул зогсолт
4	Жилд ажиллах хоног	хоног	201	
5	Хоногийн ажлын горим	ээлж	2	
6	Ээлжийн хугацаа	цаг	12	
7	Хоногт ногдох ажлын нийт цаг	цаг	24	
8	Жилд ногдох ажлын нийт цаг	цаг	4,8 24	

Уурхайн ашиглалтын систем

Ордын ашигт давхарга дахь алтны тархалт жигд бус, давхаргын зузаан ордын хэмжээнд жигд үзүүлэлттэй, хучаас хөрсний зузаан ордын хэмжээнд жигд бус боловч мөнхийн цэвдэгшилтгүй, давхарга нь хэвтээ, хэвгий уналтай байгаа нь уул техникийн таатай нөхцөлийг бүрдүүлж байна. Ордын элсний угаагдах чанар хөнгөн, бул чулууны агуулга бага гэсэн ангилалд багтаж байгаа юм.



Зураг 1. Уурхайн ашиглалтын системийн схем

Шандын амны алтны шороон ордын уул геологийн нөхцөл, элсний давхаргын тогтоц зэргээс хамаарч тээвэртэй, дотоод овоолготой болон гадаад түр овоолготой ашиглалтын системээр ашиглахаар тооцлоо.

Ил уурхайн процесс нь хөрс хуулалт, элс олборлолт, овоолго байгуулах болон туслах ажлуудыг иж бүрнээр нь аюул осолгүй, эдийн засгийн үр ашигтай явуулах, зорилтод бүтээмжийг хангах ёстой. Ордын ашиглалтын дараах процессууд явагдана. Үүнд:

- ✚ Үржил шимт өнгөн хөрс хуулалтын ажил
- ✚ Хөрс хуулалтын ажил
- ✚ Элс олборлолтын ажил
- ✚ Элс угаалтын (баяжуулалтын) ажил
- ✚ Хөрсний дотоод овоолго, тэгшлэлтийн ажил
- ✚ Техникийн болон биологийн нөхөн сэргээлтийн ажил

Баяжуулах

Шандын ам алтны шороон ордын технологийн туршилтыг “Эпсилон-Тех” ХХК-ийн лабораторид хийлгэсэн байна. Ил уурхайн элс олборлолтын төлөвлөгөө болон ордод хийсэн технологийн туршилтын үр дүнг үндэслэн Шандын амны алтны шороон ордын элс баяжуулалтын технологийн тооцоо, тоног төхөөрөмжийн тооцоо, сонголтын үр дүнг энэхүү бүлэгт тусгалаа. Төсөлд тусгаснаар элс угаан баяжуулах цех нь ашиглалтын хугацаанд сийрэгжсэн эзлэхүүнээр нийт 408.7 мян.м3 элс баяжуулах бөгөөд элс угаалт баяжуулалтын


ажиллагааг улирлын чанартайгаар 2 жилийн хугацаанд ажиллахаар төлөвлөн ТЭЗҮ–д тусгасан болно.

Элс угаан баяжуулах

Төсөлд элс угаан баяжуулах цехийн технологийн шийдлийг тусгахдаа элс олборлолтын төлөвлөгөө болон лабораторид гүйцэтгэсэн технологийн туршилтын үр дүнг үндэслэсэн. Ордын элсийг скрубберт угаах төхөөрөмж болон шлюз, баяжуулах ширээний дамжлагаар угаан баяжуулна.

Элс угаан баяжуулах цехэд скруббер-угаан ангилах тоног төхөөрөмжүүд нэг шугамаар ажиллана. Скрубберээр +20 мм, -20 мм-ийн ширхэглэлтэй элсийг угаан ангилаад шлюзээр баяжуулна.

Шлюзнээс гарсан баяжмалыг гүйцээн баяжуулах цехэд баяжуулах ширээгээр баяжуулж шлихийн алтыг гарган авна. Баяжуулалтын технологийн схемийг дараах зурагт үзүүлэв.



Зураг 2. Баяжуулах технологийн схем

1.3 Төслийн дэд бүтэц

Хүснэгт 3. Уурхайн дэд бүтэц, талбай

Д/д	Эдэлбэр газрын нэр	Талбайн хэмжээ, га	Уурхайгаас алслагдсан зай, м
1	Уурхай	18.9	-
2	Хотхон болон засварын талбай	2.2	250 (зүүн хойд зүгт)
3	Баяжуулах үйлдвэр	1.4	150 (зүүн урд)
4	Гадаад овоолго	1.0	
5	Авто зам	2.5	-
	Нийт дүн	26.0	



Зураг 3. Уурхайн кемп

Засварын цех, агуулах

Тус уурхайн тоног төхөөрөмжийн засвар, техникийн үйлчилгээний газар нь тоног төхөөрөмж, авто тээврийн болон бусад тоног төхөөрөмжийн найдвартай ажиллагааг хангахын тулд урсгал засвар, техникийн үйлчилгээ хийх, ашиглалт засварын хэрэгцээнд зориулсан материал, сэлбэг, тос, түлш зэргийг хүлээн авах, хадгалах, тавьж олгох зэрэг ажлыг гүйцэтгэнэ.

Тоног төхөөрөмжийн их засвар, зарим нарийн төвөгтэй эд ангийг сэргээх, бүрэн солих зэрэг ажлыг засварын дагнасан газраар буюу тоног төхөөрөмжийг нийлүүлсэн газрын засварын газраар гүйцэтгүүлэнэ. Засварын цехид өрөм, точиль, гагнуурын аппарат зэрэг тоног төхөөрөмжүүдийг байрлуулна.

Шатах тослох материалын агуулах: ШТМ хадгалахад зориулж 20 тн-ын контейнер, тос тосолгооны материалуудыг зориулалтын савтай нь байна. ШТМ-ын агуулахыг гал, ариун цэвэр, эрүүл ахуйн шаардлагын норм дүрмийн дагуу байрлуулан, зориулалтын тоноглолоор хангасан байна.

Сэлбэг материалын агуулах: Уурхайн тоног төхөөрөмжийн тоо, бүтцээс хамааруулан сэлбэг материал хадгалахад зориулан засварын цехийн өрөөний хажуугийн тасалгааг ашиглахаар тусгав

Цахилгаан хангамж

Уурхайн цахилгаан хангамжийг дизель станцаар хангаж, дизель генераторыг цахилгаан хэрэглэгч тус бүрийн дэргэд байрлуулахаар тооцсон.

Усан хангамж

Тус ордыг уурхайлан олборлох явцад гүний усны ундаргагүй нь тогтоогдсон. Иймд технологийн усны хэрэгцээг уурхайгаас 9 км-ийн зайд байрлах туул голоос ус татаж уурхайн технологийн усыг ханга. Баяжуулах цехэд шаардлагатай усыг голын уснаас усны машинаар зөөж хангахаар төлөвлөсөн. Гол дээр насос станц байрлах бөгөөд баяжуулах цехийн ус хангамжийн зөөврийн машинд ус шахах үүрэгтэй байна.

Тосгоны ахуйн хэрэглэх усыг төслийн талбайд өрөмдөж тоногловсон гүний худгаас хэрэглэж байгаа бөгөөд төсөлд хотхоны ундны усыг тус гүний худгаас үргэлжлүүлэн авч ашиглахаар тооцлоо.

Уурхайн зам

Үйлдвэрлэлийн талбай, баяжуулах үйлдвэр, гадаад тээврийн авто замуудыг уурхайтай сайжруулсан хайрган хучилттай замаар холбоно.

Үйлдвэрлэл, ахуйн хог хаягдал

Уурхайн хэмжээнд ахуйн гаралтай, үйлдвэрийн гаралтай (засвар үйлчилгээнээс гарах хаягдал) гэсэн 2 төрлийн хог хаягдал гардаг. Ахуйн гаралтай хог хаягдлын түр цэгийг салхин дор, ажилчдын гэр байраас 100 м зайд байрлуулсан.

Хог хаягдлын цэгийг байгуулахдаа хатуу, шингэнээр нь ялган хаяж байхаар төлөвлөсөн бөгөөд ингэхдээ мөн дахин ашиглагдах, эс ашиглагдахаар нь ялгаж байна.

БҮЛЭГ 2. ТӨСЛИЙН ТАЛБАЙ ТҮҮНИЙ ОРЧМЫН БАЙГАЛЬ ОРЧНЫ ТӨЛӨВ БАЙДЛЫН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ

2.1 Төсөл хэрэгжих талбайн байршил, физик газарзүйн нөхцөл

Далайн төвшнээс дээш 1500-1700 м өргөгдсөн. Физик газар зүйн хувьд Хэнтийн нурууны захын уулсын мужид, геоморфологийн хувьд Орхон-Сэлэнгийн бэсрэг уулсын Туулын дэд мужид багтдаг. Газар хөдлөлийн эрчим 7 балл. Сумын нутаг дэвсгэр нь уул, гүвээ толгод бүхий тал хээр, мал аж ахуй болон газар тариалан эрхлэхэд тохиромжтой.

Газар зүй: Орд нь Хангайн уулархаг мужийн өмнөд хэсэг болох жижиг нурууд ба хүчтэй хэрчигдсэн уулсын гадарга зонхилсон Туулын их тохойрлын баруун эрэгт оршино. Талбай нь далайн түвшнээс дээш 1000 м өргөгдсөн байдаг. Энэ хавийн томоохон уулс нь ихэвчлэн хавтгай орой, эгц хажуутай байдаг бол нам уулс ба толгод нь шовх орой, налуу хажуутай байдаг онцлогтой. Жижиг нурууд ба уулсын тарамцгуудыг зааглагч хөндийнүүдийн хажуу төдийлөн эгц биш, налууvtар, байдаг.

Ордын талбай нь Монгол орны газар зүй - геологийн мужлалаар Хангай-Хэнтийн дүүргийн хойд Хэнтийн металлогенийн бүсэд багтана. Судалгааны талбай нь тектоник структурын хувьд Монгол Өвөр байгалийн атираат мужын Хангай- Хэнтийн бүтэц хэлбэршлийн бүсийн төв хэсэгт багтана. Тухайн районд каледоны цаг үед бүрэлдэн тогтсон Хэнтийн структур формацийн бүсэд дунд кембрий - доод ордовикийн үеийн субдукцийн бүсийн аккрецийн шаантаг гаралтай Хараагийн серийн флиш маягийн терриген хурдас тархсан байна. Тухайн районд хожуу карбон - түрүү пермийн Тарвагатайн комплекс, хожуу пермийн Хангайн комплексийн интрузив чулуулаг тархсанаас гадна орчин үеийн сэвсгэр хурдас голын хөндий, тэдгээрийн цутгалуудад тархсан байдаг.

Төсөл хэрэгжих орон нутгийн газар нутаг, засаг захиргаа

Төв аймгийн Лүн сум нь 1924 онд байгуулагдсан, хуучнаар Түшээт хан аймгийн Мэргэн алтганатай нэрээр байгуулагдсан. Цагаан-Уул, Өгөөмөр, Төв гэсэн 3 багийн нийт 787 өрхөд 2588 хүн амьдардаг. Хүн амын тоогоор Төв аймгийн 27 сумаас 18-д, газар нутгийн хэмжээгээр 12-д ордог, хүн амын нягтралаар дунд зэрэг сум юм.

2.2 Төсөл хэрэгжих орон нутгийн уур амьсгал

Уур амьсгал: Район нь эх газрын эрс тэс уур амьсгалтай, агаарын температурын жилийн дундаж нь -7.1°C байдаг. Лүн сумын төвд байрлах цаг уурын станцын ажиглалтаас харахад хамгийн хүйтэн нь 1-р сард -37°C , дулаан нь 8-р сард $+29^{\circ}\text{C}$ байна. Жилд унах тунадасны дундаж хэмжээ 110 мм бөгөөд түүний ихэнх хэсэг нь зуны улиралд бороо хэлбэрээр унадаг. Салхи өвөл зундаа тогтуун, хавартаа дунджаар 2.6 м/сек байдаг. Цасан бүрхүүлийн зузаан нэлээд их, зарим үед 1 м гаруй болдог.

Төсөл хэрэгжих талбай орчинд жилдээ 290-305 мм хур тунадас унадаг. Энэ нь өндөр уулсын нутгаас бага боловч говь цөлөөс бол бүр их байна. Дулааны улиралд хур тунадасны 92% буюу 282 мм орно. Дулааны 4-10 сард бороо, үлдсэн 15% орчим нь хүйтэн улирлын 11-3 саруудад цас хэлбэрээр орно. Хур тунадас жилээс жилд хэлбэлзэл, өөрчлөлт ихтэй байдаг. Салхины дундаж хурд 4-8 м/сек, голдуу баруун хойд, хойд, зүүн хойд зүгээс салхилах бөгөөд заримдаа 20-22 м/сек хүрдэг.

Салхи төлөв: Нийт нутгаар 0.8-2.8 м/с байснаас Жаргалант, Батсүмбэр, Мөнгөнморьт, Аргалант суманд 0.8 м/с, Эрдэнэсант суманд 2.8 м/с байв. Салхины их хурд: 10-20 м/с

байснаас Мөнгөнморьт суманд 10 м/с, Угтаал суманд 20 м/с хүрч салхилсан. 15 м/с-ээс дээш хурдтай өдрийн тоо : Бүрэн суманд 3 удаа, Зуунмод, Баян, Угтаал, Лүн суманд тус тус 1 өдөр ажиглагдсан.

Цасан бүрхүүл: Бүх сумдын нутгаар цасны өндөр 1-9 см бөгөөд 6-10 балл цастай байснаас Зуунмод, Мөнгөнморьт, Баяннөжүүл, Баянчандмань, Угтаал, Борнуур, Алтанбулаг сумдад 6-9 см цастай, 0.13-0.22 гр/см³ нягттай байв. Жилд 34 өдөр шороон шуургатай 92 цаг үргэлжилдэг байна. Шороон шуургатай өдрийн 61.3 хувь нь 3-бдугаар саруудад /19/ ажиглагддаг. / 3 өдрөөр нэмэгдсэн/ Жилд 15 м/сек-ээс дээш салхитай өдөр 18 , сүүлийн жилүүдэд 3 өдрөөр нэмэгдсэн. Тус нутагт салхины дундаж хурд 1.7 м/сек бөгөөд 28 м/сек-ээс дээш хүчтэй салхитай өдрийн тоо сүүлийн 10 жилд дунджаар 7 өдөр байна.

Төсөл хэрэгжих нутагт хойд, баруун хойд, зүүн хойд зүгийн салхины чиглэл ноёлдог тул олборлох үйл ажиллагаанд энэ салхины чиглэлийг анхаарч үзвэл зохино.

Агаарын чанар: Тухайн орчинд байгалийн болон антропологийн гаралтай агаарын бохирдлын ямар нэг илрэл байхгүй бөгөөд цаашид энэхүү цэнгэг агаартай орчны унаган төрхийг хадгалан өөрсдийн эрхлэх уул уурхайн үйл ажиллагаандаа дэвшилтэт арга технологи ашиглах нь зүйтэй.

Тухайн бүс нутгийн агаарын чанарыг үнэлэхдээ агаарын чанарын индекс гэсэн хэмжигдэхүүнээр тодорхойлдог. Энэ индекс нь хот суурин газрын хүрээлэн байгаа агаар дахь бохирдуулагч бодисын тухайн үеийн агууламжийг түүний стандартад заагдсан хүлцэх хэм хэмжээнд харьцуулсан тоон үзүүлэлтээр гардаг. Агаарын чанарын индексийг /АЧИ/ агаар дахь түгээмэл тархалттай үндсэн бохирдуулагч бодисоор тодорхойлдог бол хүхэрлэг хий болон азотын давхар исэл нь агаар дах үндсэн бохирдуулагчид нь юм. Дээрх үндсэн бохирдуулагчдыг ашиглаж Лүн сумын агаарын чанарын индексийг дараах графикаар дүрслэн үзүүлээ.

Агаарын чанарыг агаарын чанарын индексээр 6 түвшинд ангилдаг бөгөөд 0-50-н хооронд цэвэр, 51-100-н хооронд хэвийн, 101-250-н хооронд бага зэргийн бохирдолтой, 251-400-н хооронд дунд зэргийн бохирдолтой, 401-500-н хооронд их бохирдолтой, 501-с их бол маш их бохирдолтой гэж хуваадаг. Сэлэнгэ аймгийн нутагт 2013, 2014 онд агаарын чанарын индекс хэвийн үзүүлэлттэй байсан бол сүүлийн жилүүдэд бага зэргийн бохирдолтой гэсэн ангилалд багтах болжээ. Агаарын бага зэргийн бохирдол нь зүрх судас, амьсгалын замын архаг өвчтэй, хэт мэдрэг хүмүүсийн эрүүл мэндэд илүү сөргөөр нөлөөлдөг байна.

2.3 Төсөл хэрэгжих талбайн хөрсөн бүрхэвч

Хөрсөн бүрхэвч: Аймгийн нутгийн өмнө ба баруун хэсгээр хээр талын хүрэн, цайвар хүрэн хөрстэй, зүүн хойд хэсгээр нь ам хөндийн бараан хөрс, уулын ой, нугын саарал хөрс тархжээ. Монгол орны хөрс-газарзүйн мужлалын хувьд Хангайн их муж Хэнтий муж, Хэнтийн захын 39-р тойрогт хамаарагдаж байна. “Шандын ам” алтны шороон орд орчим хархүрэн хөрс, сайргархаг нимгэн хархүрэн хөрс, Нугархаг Хархүрэн зэрэг хөрснүүд тархсан байна үржил шим сайтай хөрс байна.

2.4 Төсөл хэрэгжих талбайн ургамлан нөмрөг, амьтны аймаг

Амьтны аймаг: Орд газар нь Монгол орны амьтны аймгийн мужлалаар Хэнтийн тойрогт хамаарагдах ба амьтны аймгийн зүйлийн бүрдэл нь ойт хээр, хээрийн амьтдаас бүрдэнэ. 2016-2017 онд “Шандын ам” алтны шороон орд газар орчимд бүртгэгдсэн 53 зүйл шувуудын 28.3% нь суурин, 20% нь нүүдлийн үед дайрч өнгөрдөг бол 26.4% нь зусаж

үрждэг шувууд байна. Нүүдлийн шувуд дайран өнгөрөх, мөн зусаж үржих гол орчин нь голын сав газар юм. МАА, Газар тариалан эрхлэх иргэдийн суурьшилт, зам харилцаа зэргээс шалтгаалан том хөхтөний тархалт хязгаарлагдсан ба судалгаа ажиглалтын хугацаанд бор гөрөөс, зэрлэг гахай, монгол тарвага зэрэг том хөхтөн амьтад үзэгдээгүй.

Богино хугацааны ажиглалт судалгааны явцад ажиглагдсан хөхтөн амьтад болон амьдрах орчны нөхцөл, хөхтөний үлий нүх, мөр, ялгадас зэрэг мөр шинж тэмдгийг ашиглан төслийн талбайд 9 зүйлийн хөхтөн байгааг тогтоосон. Цаашдын судалгаагаар хөхтөний зүйлийн тоо нэмэгдэх боломжтой.

Ургамлын нөмрөг: Судалгаа явуулсан нутаг нь ургамал газарзүйн мужлалаар Евро-Азийн хээрийн муж, Дагуур Монголын хээрийн хошуу, Баруун Хэнтийн уулын хээрийн тойрог, Туул голын дүүрэгт хамаарагдана. Туул голын дүүрэгийн ургамал бүлгэмдлийн ихэнх нь тал хээрийнх. Үетэн ба алаг өвст хээр голлож тааралдах бөгөөд тэдгээр нь уулын ар биеэр тачир ургамалтай уулын хээрийн шинжтэй байдаг. Хэрлэн голоос эхлэн Туул хүртэл Туул голын баруун эрэг дагуух ихээхэн нутагт жижиг навчит харгана (*Caragana microphylla*) бүхий жинхэнэ үетэн агьт хээр тааралддаг. Хотос хоолойгоор марцлаг нуга, дэрс үзэгддэг (А.А.Юнатов, 1977 он).

Судалгаа гүйцэтгэсэн талбай нь уулын хээрийн бүсэд хамаарах 2 бүлгэмдлээс бүрдэнэ. Хангай, Хэнтийн салбар уулсад хуш, шинэс, улиас, бургас, нарс, яшил, яргай зэрэг янз бүрийн модтой, өрөл, мойл, үхрийн нүд, нохойн хошуу зэрэг жимс, сонгино, хөмөл, таана, мангир, халиар, гичгэнэ, мөөг зэрэг хүнсний ургамал, чихэр өвс, чацаргана мэтийн ховор болон дэгд, бадаана, таван салаа, тарваган шийр, алтан гагнуур зэрэг эмийн ургамал ургана.

2.5 Төсөл хэрэгжих талбайн гадаргын болон гүний ус

Усан сүлжээний хувьд: Туул гол нь Монгол улсын төв, хойд хэсгээр урсах гол юм. 819 км урттай бөгөөд ус цуглуулах талбай нь 49,840 км². Хэнтий, Төв, Сэлэнгэ аймаг болон Улаанбаатар хотын нутгаар урсан өнгөрнө. Сав газрын өндөршил нь 770-2800 метрийн хооронд байх ба хамгийн өндөр цэг нь далайн түвшнээс дээш 2799.3 метрийн өндөрт өргөгдсөн Асралт Хайрхан уул, хамгийн нам цэг нь далайн түвшнээс дээш 770 метрийн өндөр Орхон-Туулын бэлчир газар юм.

Гадаргын ус

Төслийн талбайгаас 9км зайд Туул гол нь байна. Туул голын сав газар нь 5 аймгийн 37 сум, Улаанбаатар хотын 7 дүүргийн нутаг дэвсгэрийг хамран нийтдээ 49774.3 км² талбайг эзэлж байна. Туул голын сав газарт Улаанбаатар хотын эдэлбэр газрын 65.5 хувь, Төв аймгийн газар нутгийн 39.8 хувь, Булган аймгийн 20.8 хувь, Төв аймгийн 6.0 хувь, Архангай аймгийн 4.4 хувь, Сэлэнгэ аймгийн 2.2 хувь нь хамрагдаж байна. Хэрлэн, Туул зэрэг том жижиг 30 гаруй голтой. Жанчивлан, Цайдам, Цахир зэрэг бүрд нууруудтай.

Төслийн талбай орчмын гадаргын ус:

Газрын доорх ус

Судалгааны талбай нь Монгол орны гидрогеологийн мужлалаар Хангай Хэнтийн гидрогеологийн их мужид Туул голын ай савд хамаарагдана. Түүрүү судлаачдын үзэж байгаагаар талбайн гидрогеологийн нөхцөл нь геоморфологийн онцлог, геологийн тогтоц, жилд унах хур тунадасны хэмжээнээс хамаарч харилцан адилгүй тогтоогдсон байна. Судалгааны талбайд гидрогеологийн хувьд сэвсгэр хурдасны тунамал хувирмал чулуулгийн

болон интрузив чулуулгийн уст бүрдлүүд байдаг. Тэдгээрийг дараах давхаргуудад ялгасан юм.

1. Дөрөвдөгчийн хурдасны ус агуулагч бүрдэл
2. Хожуу кембри-доод ордовикийн ус агуулагч бүрдэл
3. Палеозойн гүний чулуулгийн ус агуулагч бүрдэл

“Шандын ам” алтны шороон ордын гидрогеологийн нөхцөл

Ордын гидрогеологийн нөхцөл нь геоморфологийн онцлог, геологийн тогтоц, жилд унах тунадасны хэмжээнээс хамааралтай байдаг. Уг ордын талбайд гол горхи болон булаг шанд байхгүй. Хайгуулын шурфуудад 6.0 м гүнд хөрсний ус болон олон жилийн цэвдэг илрээгүй. Ийм учраас ордыг ашиглах үеийн ундааны ба техникийн усны хэрэгцээг ордоос 9 км-г урсан өнгөрдөг Туул голоос хангана.

2.6 Төсөл хэрэгжих орон нутгийн нийгэм эдийн засгийн байдал

Төсөл хэрэгжих орон нутгийн хүн ам:

Төв аймгийн Лүн сум нь 1924 онд байгуулагдсан, хуучнаар Түшээт хан аймгийн Мэргэн алтганатай нэрээр байгуулагдсан. Цагаан-Уул, Өгөөмөр, Төв гэсэн 3 багийн нийт 787 өрхөд 2588 хүн амьдардаг. Хүн амын тоогоор Төв аймгийн 27 сумаас 18-д, газар нутгийн хэмжээгээр 12-д ордог, хүн амын нягтралаар дунд зэрэг сум юм.

Далайн төвшнээс дээш 1500-1700 м өргөгдсөн. Физик газар зүйн хувьд Хэнтийн нурууны захын уулсын мужид, геоморфологийн хувьд Орхон-Сэлэнгийн бэсрэг уулсын Туулын дэд мужид багтдаг. Газар хөдлөлийн эрчим 7 балл. Сумын нутаг дэвсгэр нь уул, гүвээ толгод бүхий тал хээр, мал аж ахуй болон газар тариалан эрхлэхэд тохиромжтой.

Эрүүл мэнд: Лүн Суманд 10 ортой 1 эмнэлэг, 1 эмийн сан үйл ажиллагаа явуулж байна. 2 их эмч, 11 эмнэлгийн тусгай мэргэжилтэн ажиллаж байна. 2012 онд нийт 59 хүүхэд мэндэлж, 0-1 хүртэлх насны хүүхдийн эндэгдэл 1 гарсан 1-5 хүртэлх насны хүүхдийн эндэгдэл болон эхийн эндэгдэл гараагүй. Нийт өвчлөлийг авч үзвэл халдварт бус өвчлөл 261, осол гэмтэл 22, халдварт өвчний 21 тохиолдол гарсан.

Боловсрол, биеийн тамир спорт: Ерөнхий боловсролын 12 жилийн сургуульд 16 бүлэгт 393 хүүхэд өдрөөр суралцаж, албан бус боловсролын дүйцсэн хөтөлбөрөөр бага, суурь, бүрэн дунд боловсрол нөхөн олгох сургалтанд 30 иргэн суралцаж байна. Бага ангийн хамран сургалт 83,3 хувь, суурь боловсролын хамран сургалт 97,3 хувьд хүрсэн. Ерөнхий боловсролын сургуульд мэргэжилтэй багшийн хангалт 100 хувь байна. Мэргэжил дээшлүүлэх, хөрвөх сургалтанд нийт багшийн 70 хувь нь хамрагдсан байна. Төрийн өмчийн “Цомирлог” цэцэрлэгт 134 хүүхэд, гэр цэцэрлэгт 44 хүүхэд хамрагдаж сургуулийн өмнөх боловсролын хамран сургалт 89,4 хувьд хүрсэн. Нийт 21 багш ажилчидтай.

Хөдөлмөр эрхлэлт, ажилгүйдэл: Суманд бүртгэлтэй ажилгүй 42 иргэн байна. Нийт ажилгүй иргэдийн 35,7 хувийг эмэгтэйчүүд эзэлж байна. Бүртгэлтэй ажилгүй иргэдийг боловсролын түвшингээр нь авч үзвэл 28,5 хувийг дээд, 1.4 хувийг тусгай дунд, 70 хувийг бүрэн дунд болон бүрэн бус дунд, 0,1 хувийг бага буюу боловсролгүй хүмүүс тус тус эзэлж байна.

Бүртгэлтэй ажилгүйчүүдийн 49.0 хувийг ерөнхий боловсролтой, 29.1 хувийг дээд боловсролтой, 14.8 хувийг мэргэжилтэй ажилчид, 5.8 хувийг тусгай дунд боловсролтой, 1.3 хувийг боловсролгүй хүмүүс эзлэх боллоо. Энэ сард бүртгэлтэй ажилгүйчүүдээс 24

хүн ажилд зуучлагдан орж, 38 хүн идэвхгүйн улмаас хасагдаж, 56 хүн шинээр бүртгэгдсэн байна.

Үйлдвэрлэл: Сумын хэмжээнд жилд 22,5 га-д газар тариалан эрхэлдэг. Үүнээс 15 га талбайд төмс, 5 га-д хүнсний ногоо, жимс жимсгэнэ 2,5 га-д тариалж, 97,5 тн төмс, 35 тн хүнсний ногоо хураан авч байна.

Мал сүрэг: Мал сүргийн бүтэц Сумын хэмжээнд 212 448 толгой малтайгаас 315 тэмээ, 14435 адуу, 9766 үхэр, 115021 хонь, 72911 ямаа байна. Нийт сүрэгт тэмээ 0.15 хувь, адуу 6.8 хувь, үхэр 4.6 хувь, хонь 54.15 хувь, ямаа 34.3 хувийг тус тус эзэлж байна. Сумын хэмжээгээр нийт цэвэр үүлдэр, эрлийз, нутгийн шилмэл омгийн 1670 толгой мал тоологдсон нь нийт малын 0.8 хувь болж байна. 427 малчин өрх, 91 мал бүхий өрх байгаа нь сумын нийт өрхийн 65.8 хувийг эзэлж байна.

Хот байгуулалт газрын харилцаа: Лүн сумын төв нь Засаг захиргаа-хөдөө аж ахуй-үйлчилгээний үүрэг давамгайлсан сум юм. Сумын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг 2009 онд орон нутгийн төсвийн санхүүжилтээр боловсруулсан. Сумын төвийн нутаг дэвсгэрийн бүсчлэлийн өнөөгийн байдал: Олон нийтийн бүс 478,6 га үйлдвэрлэлийн бүс 4 ганогоон байгууламж, амралт, аялал жуулчлалын бүс 332,5 га хөдөө аж ахуйн ангилалын газар 248715,4 га 2012 оны байдлаар 1101 иргэн гэр бүлийн хэрэгцээний зориулалтаар 200,18 га газар өмчилж, 312 иргэн өвөлжөө, хаваржааны зориулалтаар 19,67 га газар, 4 иргэн, аж ахуйн нэгж амралт, аялал жуулчлалын зориулалтаар 12,5 га газар, 5 иргэн 2 аж ахуйн нэгж газар тариалангийн зориулалтаар 1600 га газар эзэмшиж байна.

Орон нутгийн төсөв, эдийн засаг: Орон нутгийн төсөв. Сумын төсвийн нийт орлого нь 291,3 сая төгрөг бөгөөд улсын төвлөрсөн төсвийн шилжүүлэг 262,6 сая төгрөг, сумын өөрийн орлого 28,7 сая төгрөг байна. Орон нутгийн нийт төсвийн зардал нь 486,9 сая төгрөг байна. Нийт зардлын 26,6 хувь нь цалин, 24 хувь нь нийгмийн даатгалын шимтгэл, 46,6 хувь нь урсгал шилжүүлэг, 2,8 хувийг нь бусад зардал эзэлж байна. Эдийн засгийн бүтэц Сумын хэмжээнд нийт 21 аж ахуйн нэгж байгууллага үйл ажиллагаа явуулж 16.3 тэрбум төгрөгийн бүтээгдэхүүн үйлдвэрлэж улсад 4,3 сая, аймагт 109.4 сая, орон нутагт 28,7 сая төгрөгийн татвар төвлөрүүлж байна. Суманд боржин чулуун үйлдвэрлэл явуулдаг “Авдрант хайрхан” төрийн өмчит улсын үйлдвэрийн газар үйл ажиллагаа явуулж байна.

3. ТӨСЛИЙН ГОЛ БОЛОН БОЛЗОШГУЙ СӨРӨГ НӨЛӨӨЛӨЛ

“Боржигт” ХХК-ний Төв аймгийн Лүн сумын нутагт орших “Шандын ам алтны шороон ордыг ил аргаар ашиглах” төслийн үйл ажиллагаа хэрэгжсэнээр тухайн бүс нутаг тодорхой хэмжээгээр элэгдэлд орно. Элэгдэл эвдрэлд оруулах гол хүчин зүйл нь авто машины хөдөлгөөнөөс тоос шороо, дуу чимээ үүсэх, барилга байгууламжийн нөлөөгөөр хөрсөн бүрхэвч болон ургамлан нөмрөг удаан хугацаанд дарагдах зэрэг юм.

Мөн төсөл хэрэгжсэнээр байгалийн гэнэтийн аюул осолд өртөх болон хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны дүрэм зөрчигдөх, техник хэрэгслийн элэгдэл эвдрэлээс сөрөг нөлөө үзүүлж болзошгүй.

3.1 Төслийн үйл ажиллагаанаас агаарын чанарт үзүүлж болзошгүй гол сөрөг нөлөөлөл

- Бүтээгдэхүүн тээвэрлэх үеийн машины утаа тортог, замын тоос үүсэх
- Барилга байгууламжийн орчмын шимт хөрс элэгдэж эвдэрснээс ургамлын нөмрөг талхлагдсанаас тоосжилт үүсэх
- Хатуу хог хаягдлыг цаг тухайд нь зайлуулаагүйгээс ялзарч муудан, үнэр орсноор агаар орчныг хойрдуулах зэрэг нөлөө үзүүлэхээр байна.

3.2 Төслийн үйл ажиллагаанаас хөрсөн бүрхэвч, ургамлан нөмрөгт үзүүлж болзошгүй гол сөрөг нөлөөлөл

Төслийн зүгээс хөрсөн бүрхэвч, ургамлан нөмрөгт дор дурдсан сөрөг нөлөөллүүдийг үзүүлэхээр байна. Үүнд:

- Барилга байгууламжийн ойр орчмын шимт хөрс элэгдэж, эвдэрснээс ургамлан нөмрөг талхлагдах
- Ачиж тээвэрлэх үеийн машин техникийн хөдөлгөөнөөс хучилтгүй зам талбайн хөрс элэгдэж, эвдрэх
- Машин техникийн эвдрэл гэмтлээс үүдэн тос, тослох материалын асгаралтаас хөрс, ус бохирдох
- Хог хаягдлыг төвлөрсөн цэгт хаяагүй, мөн ангилан ялгаагүйгээс болж хөрсийг бохирдуулах
- Ажилчдын ариун цэврийн газар болон хоолны газраас гарах шингэн хог хаягдлын байгууламж байхгүй, тэдгээрийн эвдрэл гэмтэл, дүүрэх зэрэг асуудлаас хөрс бохирдох

3.3 Төслийн үйл ажиллагаанаас гадаргын болон газрын доорх усанд үзүүлж болзошгүй гол сөрөг нөлөөлөл

Төслийн талбайн хөрсөн дэх тоос нь хүчтэй хур борооны урсцаар дамжин хөрсний ус, хөрсийг бохирдуулах гол эх үүсвэр болно. Ялангуяа гадаргын усыг бохирдуулснаар цэвэр усны амьд организмыг хордуулах аюултай. Хөрсний усны бохирдлын байдлыг хяналтын цооног болон уурхайн худгийн усанд шинжилгээхийж байнгын хяналтад байлгавал зохино. Шинжилгээний дүнд усны чанарын үзүүлэлт зөвшөөрөгдөх хэмжээнээс хэтэрсэн нөхцөлд мэргэжлийн байгууллагын оролцоотойгоор холбогдох арга хэмжээ авсны дараа үйлдвэрлэлээ үргэлжлүүлбэл зохино. Мөн уурхайн ахуйн бохир ус алдагдсанаас усны бохирдолд нөлөөлж болзошгүй тул энэ талын сөрөг нөлөөлөл үүсэхгүй байх арга хэмжээ авч

хяналт тавьж ажиллах ёстой. Бохир усыг зөөж тээвэрлэх явцад асгаж хөрс бохирдуулах, мөн зөвшөөрөлгүй цэгт асгах зэрэг асуудал гарахаас урьдчилан сэргийлж ажиллавал зохино.

3.4 Төслийн үйл ажиллагаанаас Хүний эрүүл мэндэд үзүүлж болзошгүй гол сөрөг нөлөөлөл

Уурхайн тээвэрлэлтийн тоосжилт, машин техникийн дуу шуугиан, доргио чичиргээ зэрэг нь ажиллагсдын эрүүл мэндэд сөргөөр нөлөөлөх хүчин зүйл болж, тэдний ажиллах таагүй нөхцөлийг бүрдүүлдэг байна. Уурхайн үйл ажиллагаанаас үүсэх тоосны 10 микроноос бага хэмжээтэй хэсгүүд нь хүний уушги болон амьсгалын замын эрхтнийг өвчлүүлэх гол эх үүсвэр болно. Удаан хугацаанд сөрөг нөлөөтэй орчинд ажилласнаас ажилчдын анхаарал сарних, осолд өртөх, элдэв өвчинд нэрвэгдэж, хөдөлмөрийн чадвараа түр буюу бүр мөсөн алдах зэргээр осол аюултай үр дагаврыг үзүүлнэ. Ажлын байрны эрүүл ахуй, хөдөлмөрийн нөхцөлийг шаардлагын хэмжээнд байлгаж чадсанаар ажиллагсдын мэргэжлээс шалтгаалах өвчлөл, хөдөлмөрийн чадвараа түр алдалт, үйлдвэрлэлийнослоос урьдчилан сэргийлж чадна. Ажлын байрны эрүүл ахуй, хөдөлмөрийн нөхцөлд нөлөөлөх гол хүчин зүйлүүдийг 2 бүлэгт хувааж болно.

- Физикийн хүчин зүйл (температур, харьцангуй чийглэг, тоосжилт, дуу шуугиан, гэрэлтүүлэг г.м)
- Физиологийн хүчин зүйл (ажиллагсдын эрүүл мэнд, хөдөлмөрийн чадвараа түр алдалт)

Иймд физикийн хүчин зүйлүүдийг зөвшөөрөгдөх хэмжээнээс хэтрүүлэхгүй байх, ялангуяа тоосжилт ихтэй цехийн асперацийн системийн үйл ажиллагааг тогтворжуулах, агаар орчинд ус уур тоосруулан цацах маягаар тоосжилтыг багасгах, үйлдвэрлэлийн үйл ажиллагааг иж бүрэн автомат удирдлагатай болгох зэрэг арга хэмжээ авахын зэрэгцээ мэргэжлийн хяналтын байгууллагатай хамтран ажиллавал зохино.

4. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГОЛ ЗОРИЛТ, ХАМРАХ ХҮРЭЭ

Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөө нь төсөл хэрэгжих нутаг дэвсгэрийн байгаль орчныг хамгаалах, зүй зохистой ашиглах, нөхөн сэргээх, нарийвчилсан үнэлгээний зөвлөмжийн хэрэгжилтийг хангах, нөлөөллийн нарийвчилсан үнэлгээгээр тогтоосон сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах, урьдчилан сэргийлэх, төсөл хэрэгжих орчинд бий болж болзошгүй сөрөг үр дагаврыг хянах, илрүүлэх үндсэн зорилготой.

Энэхүү төлөвлөгөөгөөр алтны шороон ордын үйл ажиллагаатай холбогдон бий болж болзошгүй сөрөг нөлөөллөөс тухайн нутаг дэвсгэрийн байгаль орчныг хамгаалах үйл ажиллагааны зорилтууд, нөлөөллийг бууруулахаар авч хэрэгжүүлэх арга хэмжээний хуваарийг тогтоож өгөв.

Тухайн жилийн байгаль хамгаалах төлөвлөгөө нь орчны хяналт шинжилгээний хөтөлбөртэй нягт уялдаатай бөгөөд төслийн хэрэгжилтийн хугацааны туршид агаар, гадаргын болон газар доорын ус, хөрсний чанар, ургамал, амьтны аймагт гарч байгаа өөрчлөлтүүдийг тухай бүрд нь шинжилж, байгаль орчин болон хүний эрүүл мэндэд үзүүлж байгаа нөлөөллийг тогтоох, түүний болзошгүй сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлж шаардлагатай арга хэмжээнүүдийг байгаль хамгаалах төлөвлөгөөнд нэмж тусгалаа.

Байгаль орчны менежментийн төлөвлөгөө нь төсөл хэрэгжих нутаг дэвсгэрийн байгаль орчныг хамгаалах, зүй зохистой ашиглах, нөхөн сэргээх, нөлөөллийн нарийвчилсан үнэлгээгээр тогтоосон сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах, урьдчилан сэргийлэх, төсөл хэрэгжих орчинд бий болж болзошгүй сөрөг үр дагаврыг хянах, илрүүлэх үндсэн зорилго бүхий эрхзүйн баримт бичиг юм.

Энэхүү төлөвлөгөөг боловсруулахдаа байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээний тайланд тусгасан байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө болон орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийг үндэслэн байгаль орчныг хамгаалах талаар авах удирдлага зохион байгуулалтын болон сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах арга хэмжээ, уг төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд шаардагдах хугацаа, хөрөнгө зардлыг бодитойгоор тооцож тусгах зорилт тавилаа.

Мөн Монгол улсын “Байгаль орчныг хамгаалах тухай” болон “Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай” хуулиуд, Байгаль орчин аялал жуулчлалын сайдын тушаалаар батлагдсан 2019 оны А/618 тоот “Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журам”, Байгаль орчинд нөлөөлөх байдлын ерөнхий үнэлгээний дүгнэлт, мөн нарийвчилсан үнэлгээний үр дүн зэргийг үндэслэл болголоо.

Байгаль орчинд бага сөрөг нөлөөтэй үйл ажиллагаа явуулахын тулд дараах үйл ажиллагааг хэрэгжүүлэх шаардлагатай.

- Байгаль орчны бохирдлоос сэргийлэх, байгалийн нөөц баялгийг зүй зохистой ашиглах зорилгоор байгаль орчинд учрах нөлөөллийг хамгийн бага байлгахад анхаарах
- Байгаль орчныг хамгаалах тухай хууль тогтоомж, бусад холбогдох хууль, дүрэм,

журам, стандартуудыг мөрдлөг болгон ажиллах

- Уурхайн барилга байгууламж барих, олборлолт хийх үед нөлөөлөлд өртөх талбайг хамгийн бага байлгах
- Байгаль орчныг хамгаалах, ажилчдын аюулгүй байдлыг хангах үүднээс ажилчдад сургалт зохион байгуулах
- Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг батлуулж, төлөвлөгөөний дагуу мониторинг, хяналт-шинжилгээ хийлгэх
- Компанийн ажилтнууд, нутгийн иргэд болон сонирхогч талуудад байгаль орчны асуудлыг нээлттэй, шударга, ил тод байлгах

5. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

Төслийн гол ба болзошгүй сөрөг нөлөөллийг бууруулахын тулд сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөг хэрэгжүүлэх шаардлагатай. Байгалийн нөөцүүд тус бүрээр нь ангилан авч үзлээ.

Хүснэгт 5. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө

№	Гол ба болзошгүй сөрөг нөлөө	Урьдчилан сэргийлэх бууруулах, арилгах арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Жилийн зардал (мян.төг)	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах стандарт, аргачлал
АГААР ОРЧИН						
1.	Тээврийн хэрэгсэл, тоног төхөөрөмжийн хөдөлгүүр дэх түлшний дутуу шаталтаас их хэмжээний хорт	Уурхайн дотоод, гадаад тээврийн замыг шаардлагатай үед чийгшүүлж усалгаа хийх /Салхи, хуурайшилт ихтэй үед тоосжилтыг багасгахдаа 2л/м ² нормоор өдөрт 2-оос доошгүй удаа усална./	Технологийн дотоод, гадаад замууд	2,000.0	Тоосжилт ихтэй үеүдэд	Агаарын тухай хууль, MNS 4585:2016 Агаарын чанар. Техникийн ерөнхий шаардлага
2.	хий ялгарч, агаарыг бохирдуулж хүний эрүүл мэндэд сөрөг нөлөөтэй. Хөрс хуулах, тээвэрлэх зэргээс тоос босч агаар бохирдох, машин	Салхи, шуурга ихтэй үед хөрс хуулах, ачиж тээвэрлэх үйл ажиллагааг хязгаарлах	Уурхайн ашиглалтын талбайд	ҮАЗ-д тусгасан	Үйл ажиллагааны туршид	Ажлын байрны агаарын эрүүл ахуйн шаардлага: MNS 4990:2010, MNS 0017-2-3-16:1998
3.	механизмын хөдөлгүүрээс хорт хий ялгарах тул хяналт шинжилгээг тогтмол явуулах	Тээвэрлэлтийн үед хурдны хязгаар тогтоох (40 км/цагаас хэтрэхгүй байх), тэмдэг, тэмдэглэгээ байршуулах, цаашид засаж сайжруулах	Гадаад, дотоод тээврийн зам	1,000.0	2026 онд	MNS 5002:2000 Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуй.
4.	Хог хаягдлыг зориулалтын саванд хадгалж, сумын нэгдсэн хогийн цэгт сар тутам зөөвөрлөн хаяж байх	Хог хаягдлыг зориулалтын саванд хадгалж, сумын нэгдсэн хогийн цэгт сар тутам зөөвөрлөн хаяж байх	Уурхайн хог хаягдлын хүрээнд	Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөнд тусгасан	Сар тутам	Шуугианы норм, аюулгүй ажиллагааны ерөнхий шаардлага MNS ISO 226:2003 Дуу чимээ- хэвийн норм, түвшний хэмжээ
5.	Ашиглагдаж буй машин техникээс ялгарах хорт утааг стандартын түвшинд байлгах, техникийн үзлэг, засвар үйлчилгээг тогтмол хийж байх	Ашиглагдаж буй машин техникээс ялгарах хорт утааг стандартын түвшинд байлгах, техникийн үзлэг, засвар үйлчилгээг тогтмол хийж байх	Төсөлд ашиглагдаж буй техник хэрэгслүүд	1,000.0	Үйл ажиллагааны туршид	
6.						

ГАЗРЫН ГАДАРГА, ХӨРСӨН БҮРХЭВЧ, УРГАМЛАН НӨМРӨГ

**ТӨВ АЙМГИЙН ЛҮН СУМЫН НУТАГТ БАЙРЛАХ “ШАНДЫН АМ” АЛТНЫ ШОРООН ОРДЫН 2026
ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ**

7.	Газрын гадарга эвдэрч, Хөрсний үржил шим алдагдах, бохирдох, эвдрэх, доройтох	Хог хаягдлаар дамжин хөрсний бохирдол үүсгэхгүйн тул хог хаягдлын эцсийн цэгт хүргэх	Ахуйн хог хаягдлын цэг	Хог хаягдлын МТ-д тусгасан	2026	Хөрс хамгаалах Цөлжилтөөс сэргийлэх тухай хууль Газрын тухай хуулийн 50.1.1
8.		Машин техникийг маршрутын замаар явахыг хянах, зураг төслөөс гадуурх хөрс, талбайг хөндөхгүй байх	Үйл ажиллагааны турш	ҮАЗ-д тусгасан	2026	MNS5914:2008, “Газар шорооны ажлын үеийн үржил шимт хөрс хуулалт, хадгалалт” MNS5918:2008, “Эвдэрсэн газрыг ургамалжуулах техникийн шаардлага”
9.		Замын усалгааг тоосжилт ихтэй үеүдэд хийж байх	Уурхайн дотоод, гадаад тээврийн зам	Агаарын чанарын хэсэгт тусгагдсан	Хуурайшилт ихтэй үеүдэд	MNS4919:2000, “Эвдэрсэн газарт хучилт хийх хөрс. Техникийн шаардлага”
10.	Ургамлан нөмрөг талхлагдахаас сэргийлэх	Ахуйн гаралтай шингэн хаягдлыг зориулалтын талбайд түр хадгалж био бэлдмэлээр тогтмол ариутгах, цаашид байгаль орчинд халгүй зайлуулах арга хэмжээг сонгон хэрэгжүүлэх	Уурхайн хог хаягдлын хүрээнд	Хог хаягдлын МТ-д тусгасан	2026 онд	“Уул уурхайн үйл ажиллагааны улмаас эвдрэлд орсон газарт техникийн болон биологийн нөхөн сэргээлт хийх аргачлал
ГАЗРЫН ДООРХ УС						
11.	Унд ахуйн болон үйлдвэрлэлийн зориулалтаар усыг хэмжээгээр	Гүний худгуудад усны чанарын хяналт шинжилгээг явуулах	Уурхайн усан хангамж хангаж буй гүний худаг	Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрт тусгасан	2026 онд	Усны тухай хууль: Зүйл 24-1.1, 1.2; Зүйл 30; Зүйл 31-1, 2, 3, 4, 5, 6, 8; Зүйл 33-1, 2, 3; Зүйл 34-1, 2; Усан орчны чанарын үзүүлэлт. Ерөнхий шаардлага”
12.	ашигласнаар усны нөөцөд сэргөөр нөлөөлөх	Ус ашиглах гэрээг холбогдох байгууллагуудтай байгуулах	Усны хэрэглээгээр	ҮАЗ-д тусгасан	2026 онд	MNS4596:1998. БОНБНҮ, Компанийн дотоод журам,
13.		Хаягдал усны дүгнэлт гаргуулах		ҮАЗ-д тусгасан	2026 онд	
14.		Усны төлбөрийг цаг тухайд нь төлөх		ҮАЗ-д тусгасан	2026 онд	
АМЬТНЫ АЙМАГ						

**ТӨВ АЙМГИЙН ЛҮН СУМЫН НУТАГТ БАЙРЛАХ “ШАНДЫН АМ” АЛТНЫ ШОРООН ОРДЫН 2026
ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ**

20.	Малын бэлчээрийг доройтуулахаас сэргийлэх	Ажилчдыг хууль бусаар ан хийхгүй байхыг анхааруулах, сургалтад хамруулах, хяналт тавих	Нийт ажиллагсдад	Агаарын чанарын хэсэгт тусгасан	2026 онд	Амьтны тухай хууль
21		Ахуйн гаралтай шингэн хаягдлыг зориулалтын талбайд түр хадгалж био бэлдмэлээр тогтмол ариутгах, цаашид байгаль орчинд халгүй зайлуулах арга хэмжээг сонгон хэрэгжүүлэх	Уурхайн хог хаягдлын хүрээнд	Хог хаягдлын МТ-д тусгасан	2026 онд	
НИЙТ				4,000.0		

6. НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН АЖЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

Ордын нөхөн сэргээлтийг “Уул уурхайн үйлдвэрлэлийн үйл ажиллагаагаар эвдэрсэн газрын нөхөн сэргээлт, Техникийн ерөнхий шаардлага MNS 5917:2008” стандартад нийцүүлэн БОНХАЖ-ын сайдын 2015 оны 03 дугаар сарын 30-ны өдрийн А-138 дугаар тушаалаар батлагдсан “Уул уурхайн үйл ажиллагааны улмаас эвдрэлд орсон газарт техникийн болон биологийн нөхөн сэргээлт хийх аргачлал”-ын дагуу гүйцэтгэх ба нөхөн сэргээлтэд шаардагдах зардлыг Байгаль орчин, уур амьсгал өөрчлөлтийн яамны сайд, Эрдэс баялаг, эрчим хүчний яамны сайдын хамтарсан 2010 оны 05 сарын 17-ны өдрийн А-132/112 дугаар тушаалаар батлагдсан аргачлалын дагуу тооцоолно.

№	Нөхөн сэргээлтийн зорилт	Нөхөн сэргээлтийн арга хэмжээ	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгжийн зардал, мян.төг	Нийт зардал, мян.төг	Хэрэгжүүлэх хугацаа (он), давтамж	Баримтлах эрхзүйнбаримт бичиг,стандарт аргачлал
							2026	
	Техникийн нөхөн сэргээлтийн гол зорилго нь биологийн нөхөн сэргээлт хийхэд зориулсан овоолгын талбайг тэгшлэх, уурхайн ашиглагдсан орон зайг хөрс шороогоор дүүргэх, хэлбэржүүлэх, хур тунадасны усыг тогтоон барих, суваг шуудуу татах, биологийн нөхөн сэргээлт хийх талбайн хэвгий, налууг стандартын шаардлагын түвшинд засаж тэгшлэх, нөхөн сэргээлт хийх талбай дээр машин, техник явах зам харгуй гаргах, нөхөн сэргээсэн талбайг үерийн аюулд	Ил уурхайн хаягдал, шимт хөрсний овоолго, хоосон чулуулгын овоолго зэргийг түрэх хучих	Үйл ажиллагаа дуусмагц	1	-	Үйл ажиллагааны зардлаар	2026 оны 3 сараас	“Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай”, “Байгаль орчныг хамгаалах тухай”, Ашигт малтмалын тухай хууль MNS5915:2008, MNS5916:2008, MNS5917:2008
		Зам талбайг тэгшлэх, алтны ил уурхайн уурхайн нөхөн дүүргэлт ба дотоод овоолго	Үйл ажиллагаа дуусмагц	1	-	Үйл ажиллагааны зардлаар	2026 оны 3 сараас	

**ТӨВ АЙМГИЙН ЛҮН СУМЫН НУТАГТ БАЙРЛАХ “ШАНДЫН АМ” АЛТНЫ ШОРООН ОРДЫН 2026
ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ**

өртөхөөс хамгаалсан суваг, шуудуу, инженерийн байгууламжийг барьж байгуулах ажил юм.	Хөрсийг сийрэгжүүлж бордох, тариалалт хийх хугацаа, усалгаа арчилгааг хийх	Үйл ажиллагаа эхэлмэгц	1		2,890.0	2026 оны 5-7 сар	
Нийт дүн мян.төг					2,890.0		

7. ТЭРБУМ МОД ТАРИХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

“Тэрбум мод” үндэсний хөтөлбөрийн хүрээнд төсөл хэрэгжүүлэгч нь 2026 онд Төв аймгийн Лүн сумын нутагт 100 ш мод тариална.

100 ш суулгац худалдан авах 1.0 сая.төгрөг бөгөөд ногоон байгууламжийн арчилгаа тордлогоо, усалгаа, тариалалтын зардалд 2 сая.төг, нийт 3.0 сая.төгрөг зарцуулагдана.

8. НҮҮЛГЭН ШИЛЖҮҮЛЭХ, НӨХӨН ОЛГОВОР ОЛГОХ ТӨЛӨВЛӨГӨӨ

Төслийн MV-020482 ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй талбайд зайлшгүй нүүлгэн шилжүүлэх шаардлагатай асуудал байхгүй байна.

9. ТҮҮХ, СОЁЛЫГ ӨВИЙГ ХАМГААЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨ

Төсөл хэрэгжих уурхайн ашиглалтын үйл явцад түүх соёлын дурсгалт зүйлс олдвол уурхайн үйл ажиллагааг түр зогсоон зохих байгууллагад мэдэгдэж, түүх соёлын дурсгалт зүйлсийг хамгаалах ажлыг зохион байгуулах болно.

10 ДҮЙЦҮҮЛЭН ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулийн 3.1.11 -д “Биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах” гэж төслийн үйл ажиллагаанд өртөгдөн унаган төрх, хэв шинж, амьдрах орчноо алдсан биологийн олон янз байдлыг өөр газарт нөхөн хамгаалах арга хэмжээг ойлгоно гэж заасан байдаг. Ашигт малтмалын ашиглалтын нөлөөлөлд өртөж буй биологийн олон янз байдлыг тухайн газартай экологийн хувьд төстэй нөхцөлд, өөр газарт дүйцүүлэн хамгаалах ажлыг тодорхойлж, хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг хэрэгжүүлэх шаардлага бий болсон тул биологийн төрөл зүйлд үзүүлэх сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, бууруулах, арилгах, нөхөн сэргээлт хийх чиглэлээр авч хэрэгжүүлэх арга хэмжээг доорх хүснэгтэд үзүүлэв.

Хүснэгт 6. Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө

№	Хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Тоо хэмжээ	Нэгжийн зардал /сая.төг/	Нийт зардал /сая.төг/	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Хэрэгжилтэд хяналт тавих
1	Орон нутгаас авсан саналын дагуу дүйцүүлэн хамгаалах ажлыг хийж гүйцэтгэх	Орон нутгийн саналын дагуу	-	-	Орон нутагтай тохиролцсоны үндсэн дээр төлөвлөнө.	2026 онд	
Нийт дүн, сая.төг							-

11. ОСОЛ, ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Хүснэгт 7. Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөө

Болзошгүй аюул осол, сөрөг нөлөө	Урьдчилан сэргийлэх, хамгаалах арга хэмжээ	Нийт зардал, мян.төг	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж
Түлшний агуулах, засварын газар, ажилчдын байр, цахилгаан үүсгүүр бүхий газруудад гал түймэр гарах магадлалтай. Мөн хаврын хуурайшилт ихтэй өдрүүдэд тамхины цог зэргээс хээрийн түймэр гарч болзошгүй	Галын болон байгалийн аюул гамшгаас урьдчилан сэргийлэх арга хэмжээний талаар сургалт, зохион байгуулах	Үйл ажиллагааны зардал	2026 онд
	Гал унтраах багаж хэрэгслийг шаардлагатай газруудад байрлуулах	1,000.0	Жил бүр
	Гал түймрээс сэргийлэх талаар анхааруулга, санамжийн хуудас хийж, шаардлагатай газруудад нүдэнд харагдахуйц газруудад байрлуулах	1,000.0	Жил бүр уурхай эхлэх үед
Үйлдвэрлэлийн осол, аваар, ажилчид бэртэх, эрүүл мэнд хохирох, амь нас эрсдэх, уурхайн үйл ажиллагаа саатах, тоног төхөөрөмж эвдэрч гэмтэх	Ажилчдыг ээлжид гарахын өмнө аюулгүй ажиллагааны зааварчилгаанд хамруулах	-	Өдөр бүр ээлжинд гарахын өмнө
	Шатахууны агуулахын бүрэн бүтэн байдалд хяналт тавьж, тодорхой ажилтанд хариуцуулна.	1,000.0	Жил бүр, жилд 1 удаа
	Осол аваар гарч хүний эрүүл мэнд хохирсон тохиолдолд яаралтай анхан шатны тусламж үзүүлэх, анхан шатны тусламжийн эмийн санг машины кабин, ажлын байрт байрлуулах	2,000.0	Жил бүрийн I улиралд байрлуулан сар бүр шалгаж байх
	Хөдөлмөр хамгааллын хувцас хэрэглэлээр бүрэн хангах	Үйл ажиллагааны зардал	Жил бүр
Жолооч нарын санамсар болгоомжгүй үйлдлээс машин техникүүд мөргөлдөх, хүн амьтан дайрах, мөргөх зэргээр гэмтээж бэртээх гэх мэт осол аваар гарах	- Жолооч нарыг аюулгүй ажиллагааны сургалтад хамруулах - Анхааруулга, замын тэмдэг тэмдэглэгээг шаардлагатай газруудад байрлуулах - Уурхайн талбай дотод таних тэмдэг тэмдэглэгээг байрлуулах	Сөрөг нөлөөллийг бууруулах зардал тусгасан	Жил бүр, жилд 1 удаа
Нийт зардал		5,000.0	

12. ХОГ, ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Хүснэгт 8. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө

Болзошгүй сөрөг нөлөөлөл	Нөлөөллийг бууруулах арга хэмжээ	Арга хэмжээний цар хүрээ	Нийт зардал мян.₮	Хугацаа ба давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
Хатуу хог хаягдлыг тогтмол зайлуулаагүйг ээс орчин бохирдох	Хог хаягдлыг цуглуулах савыг битүүмж сайтай хийх	ШТС, Ажилчдын байр	1200.0	Төслийн эхэн үед	Хог хаягдлын тухай хууль болон холбогдох журам, заалтууд Хог хаягдлын тухай хуулийн 14-р зүйл
	Хог хаягдлын хор уршиг, ангилан ялгах талаар ажиллагсдад сургалт явуулах	Нийт ажиллагсдад	200.0	Төслийн эхэн үед	
	Ил задгай хог хаяхгүй байх талаар анхааруулга санамж бүхий самбар, тэмдэгжүүлэгчтэй болгох	Уурхайн ашиглалтын талбайд	850.0	Төслийн эхэн үед	
	Хаягдал тосыг хуримтлуулах сав байрлуулах	Уурхайн ашиглалтын талбайд	1200.0	Төслийн эхэн үед	
	Аюултай хаягдлыг тусгайлан хадгалж аюултай хог хаягдлын цэгт нийлүүлэх	Ашиглалтаас гарсан дугуй, тосны шүүр, асбет бүхий тоормосны шингэн, хар тугалгатай батарей, аккумулятор, гэрлийн шил	-		
	Хог хаягдал түр хадгалах талбайг нэвчилт явагдахааргүй тохижуулах	Зориулалтын хог хаягдлын цэг	Зориулалтын хог хаягдлын цэг	Зориулалтын хог хаягдлын цэг	Зориулалтын хог хаягдлын цэг
Аюултай хог хаягдлаар хөрс бохирдох	Аюултай хог хаягдал үүсгэгчээр бүртгүүлж, аюултай хог хаягдлыг хадгалах зориулалтын цэгтэй болж төрлөөр нь ангилан ялгаж бүртгэл хөтлөх, тусгай зөвшөөрөлтэй аж ахуй нэгжид хүлээлгэн өгөх	Зориулалтын хог хаягдлын цэг	Зориулалтын хог хаягдлын цэг	Зориулалтын хог хаягдлын цэг	ЗГ-ын 116-р тогтоол
			3450,0		

13 ОРЧНЫ ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР

Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр (ОХШХ) нь “Боржигт” ХХК -аас явуулж байгаа үйл ажиллагаа, хэрэгжүүлж байгаа төсөл нь байгаль орчин, хүний амьдрах орчинд хэрхэн нөлөөлж байгаа, үзүүлж буй нөлөөлөл нь зөвшөөрөгдөх хязгаарт байгаа эсэхийг хянах үзүүлэлтүүдийг тодорхойлж, хэмжих, шинжлэх арга, стандарт, хяналт хийх байршил, давтамж зэргийг бүхэлд нь тусгасан нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний нэг чухал баримт бичиг юм.

Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр нь байгаль орчныг хамгаалан төлөвлөгөөтэй нягт уялдсан бөгөөд байгаль орчныг хамгаалахаар авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээний үр дүнг илэрхийлж, уг авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээ үр ашигтай байгаа эсэхэд үнэлэлт дүгнэлт өгөх, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээнүүдэд юуг анхаарах шаардлагатайг зааж өгнө.

Байгаль орчныг хамгаалах тухай, Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай Монгол Улсын хуулиудын дагуу “Боржигт” ХХК батлагдсан арга, аргачлалаар, итгэмжлэгдсэн тоног төхөөрөмжөөр байгаль орчны хяналт шинжилгээний ажлыг явуулах шаардлагатай. Тухайн жилд хийсэн хяналт шинжилгээний үр дүнгүүдийг жил бүрийн 12 дугаар сарын 1-ний дотор холбогдох төрийн захиргааны төв байгууллага /Байгаль орчин, аялал жуулчлалын яам/-д хүргүүлэн хянуулж, дараа оныхоо төлөвлөгөөг батлуулж ажиллах ёстой.

Орчны хяналт-шинжилгээний хөтөлбөрийг бүрэн хэрэгжүүлэх, батлагдсан арга, аргачлалаар дээжлэлт, хэмжилт хийх, холбогдох нарийвчлал, тохиргоог хангасан багаж тоног төхөөрөмжөөр шинжилгээг хийлгэх, үр дүнг шаардагдах нэгжийн системээр гаргах зэрэг бүхий л үйл ажиллагааг “Боржигт” ХХК хариуцах болно. Байгаль орчны хяналт шинжилгээг тус төслийн байгаль орчны хэлтсийн холбогдох ажилтнууд хариуцан гүйцэтгэх бөгөөд шаардлагатай тохиолдолд гаднаас мэргэжлийн байгууллагуудыг татан оролцуулна.

**ТӨВ АЙМГИЙН ЛҮН СУМЫН НУТАГТ БАЙРЛАХ “ШАНДЫН АМ” АЛТНЫ ШОРООН ОРДЫН 2026
ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ**

Хүснэгт 9. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр

№	Хяналт шинжилгээ хийх үзүүлэлтүүд	Байгаль орчны бүрэлдэхүүнд үзүүлэх нөлөөлөл	Хяналт шинжилгээ хийх байршил	Хугацаа ба давтамж	Шаардагдах зардал (мян.төг)	Баримтлах арга, аргачлал, стандарт, шаардлагууд
Хөрсний бохирдол						
1	Хөрсний агрохими хөрсний механик бүрэлдэхүүн	Хөрс элэгдэл эвдрэлд орох, үржил шимээ алдах, гадаргын унаган хэлбэр өөрчлөгдөх	Ил уурхай, овоолго, ажилчдын тосгон, ШТМ түгээх цэгийн орчим болон олборлолтод өртөөгүй цэгт	Жилд 1 удаа	100,0	MNS 3307:1991, MNS 3308:1991 Хөрс. Хөрсний химийн элементүүдийн нийт хэмжээг тодорхойлох арга, MNS 3309:1991 Хөрс. Хөрсний хялбар уусдаг давсны химийн найрлагыг тодорхойлох арга, MNS 3675:1984 Хөрсний органик бодисын хэмжээг тодорхойлох лабораторийн арга, MNS 4006:1987 Хөрс. Хөдөлгөөнт фосфор, калийг тодорхойлох MNS 3298:1991 Хөрс. Шинжилгээнд дээж авахад тавигдах ерөнхий шаардлага MNS ISO 11047:2001 Хөрсний чанар. Хөрсний усан орчны кадмий, хром, кобальт, зэс, хар тугалга, манган, никелийг тодорхойлох. Дөлний болон цахилгаан дулааны атомын шингээлтийн спектрометрийн арга MNS 3675:1984 Хөрсний органик бодисын хэмжээг тодорхойлох лабораторийн арга MNS 5850:2008 Хөрс бохирдуулагч бодис, элементүүдийн зөвшөөрөгдөх дээд хэмжээ
2	Хөрсний хүнд металлын агууламж	Хөрс хүнд металаар бохирдох, хөрс рүү нэвчих, гүний усыг бохирдуулах	Ил уурхай, овоолго, ажилчдын тосгон, ШТМ түгээх цэгийн орчим болон олборлолтод өртөөгүй цэгт	Жилд 1 удаа	100,0	
3	Хөрсний эрүүл ахуй, микробиологи	Хөрсөөр дамжин гэдэсний халдварт өвчин, нянгийн өвчнөөр өвчлөх	Ил уурхай, овоолго, ажилчдын тосгон, ШТМ түгээх цэгийн орчим болон олборлолтод өртөөгүй цэгт	Жилд 1 удаа	150,0	
						НИЙТ 960.0
Усны хяналт шинжилгээ						

**ТӨВ АЙМГИЙН ЛҮН СУМЫН НУТАГТ БАЙРЛАХ “ШАНДЫН АМ” АЛТНЫ ШОРООН ОРДЫН 2026
ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ**

2.1	Усны чанар рН, ууссан нийт давс (жингийн аргаар), усны ерөнхий шинжилгээ	Гүний худаг	Унд ахуйн ус хангаж буй гүний худаг	Жилд 1 удаа	150,0	MNS (ISO) 4867:1999 Усны чанар. Дээжийг боловсруулах, хадгалах зөвлөмж MNS 4586:1998 Усан орчны чанарын үзүүлэлт. Ерөнхий шаардлага MNS (ISO) 5667-14:2000 Гадаад орчны уснаас сорьц авах болон тээвэрлэх, гарын авлагын зөвлөмж MNS 13.060.50 Усны чанарын стандарт MNS 0900 : 2005 Ундны ус. Эрүүл ахуйн шаардлага, түүнд тавих хяналт
2.2	Усны чанар Микробиологи	Усны эрүүл ахуйн шинжилгээ		Жилд 1 удаа	160,0	
НИЙТ 700.0						
ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨРИЙН ХҮРЭЭНД ХЭРЭГЖҮҮЛЭХ АЖЛЫН НИЙТ ЗАРДЛЫН ДҮН					660.0 мян.төг	

14 БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖҮҮЛЭХ УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

Төслийн үйл ажиллагааны туршид байгаль орчинд хамгийн бага сөрөг нөлөөтэйгөөр үйл ажиллагаа явуулах үүрэг хүлээж, мэргэжлийн боловсон хүчнээс бүрдсэн байгаль орчны асуудал хариуцсан байгаль орчны алба байгуулах ба төслөөс үзүүлж байгаа сөрөг нөлөөллүүдийг бууруулах, арилгах, байгаль орчныг хамгаалах арга хэмжээ авч ажиллах боловч төслийн удирдлагын хэмжээнд онцгойлон анхаарч хэрэгжүүлэх арга хэмжээнүүд байна.

Хүснэгт 10. Удирдлага зохион байгуулалт зардлын төлөвлөгөө

Урьдчилан сэргийлэх, хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Нийт зардал, сая.төг	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах стандарт, аргачлал
Байгаль орчны талаар баримтлах бодлого, байгаль орчинд нөлөөлөх сөрөг нөлөөллийг бууруулах чиглэлээр компанийн дотоод бодлогын баримт бичиг боловсруулах	Үйл ажиллагааны хүрээнд	1.0	2026	Байгаль орчныг хамгаалах тухай хууль
Уурхайн ажилчдыг хөдөлмөр хамгааллын хувцас хэрэгслээр бүрэн хангах	Үйл ажиллагааны хүрээнд	1.0	2026	Уурхайн дотоод журам
Байгаль орчны удирдлага зохион байгуулалтын арга хэлбэрийг үйл ажиллагаандаа хэрэгжүүлэх чиглэлээр үүрэг хариуцлагын дотоод журам боловсруулж мөрдөх	Үйл ажиллагааны хүрээнд	ҮАЗ-д тусгасан	2026	Байгаль орчныг хамгаалах тухай хууль
Байгаль орчны аудит хийх	Үйл ажиллагааны хүрээнд	ҮАЗ-д тусгасан	2026	
Галын аюулаас хамгаалах хэрэгсэл, эрүүл ахуйн хэрэгслээр хангах	Нийгмийн хариуцлагын хүрээнд	1.0	Төслийн хугацаанд	
Нийт, сая.төг			3.0	

15. БОМТ-Г ХЭРЭГЖИЛТИЙН НӨЛӨӨЛӨЛД ӨРТӨГЧ ОРШИН СУУГЧИД, ОРОЛЦОГЧ ТАЛУУДАД ТАЙЛАГНАХ ТӨЛӨВЛӨГӨӨ

Төсөл хэрэгжүүлэгч “Боржигт” ХХК жил бүр БОМТ-ний хэрэгжилтийн талаар байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад тайлан хүргүүлэх ба байгаль орчны хяналтын улсын байцаагч, орон нутгийн байцаагч, бүх шатны Засаг даргад тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийн тайланг жил тутамд хүргүүлнэ.

Төсөл хэрэгжүүлэгч нь уурхайн үйл ажиллагаанаас байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг хамгийн бага түвшинд байлгах, байгаль орчны бохирдлоос сэргийлэх, тогтвортой уул уурхайг дэмжих үүрэг хүлээсэн бөгөөд ажилчид, орон нутгийн иргэд болон бусад сонирхогч талуудад төслийн байгаль орчны бодлого үйл ажиллагааг нээлттэй болгох, ажил хэрэгч харилцааг дэмжих үүднээс төслийн БОМТ, түүний хэрэгжилтийг оролцогч, сонирхогч талуудад тайлагнан, хэлэлцүүлнэ. Тус хэлэлцүүлгийг жил бүр 10-р сард зохион байгуулах ба тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайланд хэлэлцүүлгийн үр дүнг оруулна.

Хүснэгт 11. БОМТ, түүний хэрэгжилтийг тайлагнах төлөвлөгөө

БОМТ, түүний хэрэгжилтийг тайлагнах, хэлэлцүүлэх оршин суугчид, оролцогч талууд	Тайлагнах, хэлэлцүүлэх хэлбэр	Мэдээний агуулга	Хугацааны тов	Хэлэлцүүлгээр санал авах чиглэл	Зохион байгуулах газар
БОУАӨЯ болон Төв аймгийн Байгаль орчны газарт	Цахимаар	Тухайн жилийн БОМТ-ийн хэрэгжилтийн тайлан	11-р сар	-	-

**ТӨВ АЙМГИЙН ЛҮН СУМЫН НУТАГТ БАЙРЛАХ “ШАНДЫН АМ” АЛТНЫ ШОРООН ОРДЫН 2026
ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ**

Хүснэгт 12. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний нийт зардал /2026 он/

Д/д	Хөрөнгийн зориулалт	Хэмжих нэгж	Жилийн зардал
1	Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө /хөрс, ус, агаар, ургамал, ан амьтан/	төгрөг	4,000,000
2	Нөхөн сэргээлтийн ажлын зардал	төгрөг	2,890,000
3	Тэрбум мод тарих төлөвлөгөөний зардал	төгрөг	3,000,000
4	Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө	төгрөг	Орон нутагтай тохиролцон дүйцүүлэн хамгаалах ажил хийнэ.
5	Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээний төлөвлөгөө	төгрөг	-
6	Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө	төгрөг	-
7	Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөө	төгрөг	5,000,000
8	Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх арга хэмжээний төсөв	төгрөг	3,450,000
9	Удирдлага зохион байгуулалт зардлын төлөвлөгөө	төгрөг	3,000,000
10	Орчны хяналт-шинжилгээний хөтөлбөр	төгрөг	660,000
11	БОМТ -г орон нутагт тайлагнах	төгрөг	-
	Дүн	төгрөг	22,000,000